**БАТЛАВ:**
**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ**
**ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЗАЯАБАЛ**

# АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2019.02.26

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | | Хугацаа | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хүрэх үр дүн | Хэрэгжүүлэх нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| **Эрх зүйн үндэслэл:**<br>• **Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9;**<br>• **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1; 4. 1.1.1; 4.1.1.2; 4.1.1.6;** | | | | | | |
| 1 | Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр | 1.1 Төрийн албан төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | жилдээ | Шинээр томилогдож байгаа албан хаагчийн мэдлэг, боловсрол, чадвар, туршлагыг харгалзан, Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилно. | Төрийн жинхэнэ албан хаагчийгтомилох, чөлөөлөх асуудлыг төрийн өндөр албан тушаалтан болон улс төрийн намын нөлөөллөөс ангид байлгаж, мэдлэг, боловсрол, чадвар, ёс зүйд суурилан томилсон байна. | ТЗУГ /Татварын албад/ |
| | | 1.2 Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх | жилдээ | | | |
| | | 1.3 Татварын албаны ёс зүйн дүрмийг батлах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх | жилдээ | Татварын албаны ёс зүйн дүрмийг шинэчлэн батлуулж, ёс зүйн дүрмийг чанд дагаж мөрдөх талаар сурталчилсан байна. | Хариуцлагатай, ёс зүйтэй алба болох нөхцөл бүрдсэн байна. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.4 Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх | жилдээ | Гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэл хөтлөн, шийдвэрлэсэн байна. | | |

Эрх зүйн үндэслэл:

- Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2; 6.1.6;
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.10.1: 4. 1.1.1 0:

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх зорилтыг хангах чиглэлээр | 2.1. Авлига, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, чиглэлээр албан хаагчдад Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилах, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах, | жилдээ | Албан хаагчдыг хамруулсан сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран байгуулсан байх, Сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлсэн байх | Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа бэхжин,авилга гэмт хэрэгт өртөх эрсдэл буурсан байна. | ТЗУГ, СТ, ХХХГ /Татварын албад/ |

Эрх зүйн үндэслэл:

- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.1: 4. 1.2.2:

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | Тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх боломжоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх | 3.1. Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг иргэд, олон нийт, сонирхогч бүлэгт мэдэгдэх, санал авах ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх | жилдээ | Байгууллагын цахим хуудсаар болон бичгээр саналыг хүлээн авч, боломжтой саналыг тусгаж ажилласан байна. | Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрт олон нийтийн санал тусгагдаж, хэрэгжилт сайжирсан байх. | ТУХАГ, ХХХГ, /Татварын албад/ |

Эрх зүйн үндэслэл:

- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.1: 4.1.2.4:

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах | 4.1 Татварын үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн цахим үйлчилгээний жагсаалтыг батлуулах | жилдээ | Цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний жагсаалтыг шинэчилсэн байх | Татварын үйлчилгээг цахим хэлбэрээр үе шаттай, иргэд, олон нийтэд хүргэсэн байна. | МТСТ |
| | | 4.2 Татвар төлөгчийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг зохион байгуулах, хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах | жилдээ | Хяналт шалгалтын төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн байх<br>Хяналт шалгалтын үр дүнд эрсдэлийн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлаар дүгнэлт, зөвлөмж гарган цахим хуудсанд байршуулсан байх | Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүнгээр гарах зөрчил багассан байна. | ТХШАЗГ<br>ЭУГ<br>/Татварын албад/ |
| Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4<br>• Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.3.3: | | | | | | |
| | | 5.1 Байгууллагын санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх | | | | |
| | | 5.2 Байгууллагын тухайн жилийн төсөв /1 сарын 10-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл | 4 сарын 01-ний дотор | | | |
| | | 5.3 Сар, улирлын төсвийн гүйцэтгэл | дараа сарын 8-ны дотор | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх | 5.4 Хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан | 8 сарын 15-ны дотор | | | Байгууллагын төсвийн орлого, зарцуулалтад иргэд, олон нийтийн зүгээс хяналт тавих боломжуудыг хангаж ажиллав. | СХОХ /Татварын албад/ |
| | | 5.5 Жилийн эцсийн санхүүгийн тайлан, Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт | 4 сарын 25-ны дотор | | | | |
| | | 5.6 Төсвийн татварын орлогын мэдээг нээлттэй болгох | сар бүрийн 8-ны дотор | | | | ТОГ |
| | | Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл | Тухай бүр | | | | ТУХАГ, СХОХ, /Татварын албад/ |
| **Эрх зүйн үндэслэл:**<br>• **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.4; 4.1.4.1;** | | | | | | | |
| 6 | Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны шударга, ил тод, нээлттэй | 6.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө | 1 сарын 10-ны дотор | Байгууллагын цахим хуудсанд байршуулсан байх | | Худалдан авах ажиллагааны хяналт, | СХОХ /Татварын |
| | | 6.2. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур, тендерийн урилга | Жилдээ | Тендерийн шалгаруулалтын журам, урилгыг цахим хуудсанд байршуулсан байх | | | |
| | | 6.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчдийн талаарх мэдээлэл болон шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааны жагсаалт | Тухай бүр | Байгууллагын цахим хуудсанд байршуулсан байх | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байдлыг нэмэгдүүлж, хяналт хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр | 6.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, | Сар бүр | Байгууллагын цахим хуудсанд байршуулсан байх | хариуцлага нэмэгдсэн байна. | албад/ |
| | | 6.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, хяналт, шалгалтын дүн | Тухай бүр | Тайлан дүгнэлт болон шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулсан байх | | |
| | | 6.6. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухай салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах | Тухай бүр | Төлөөллийг оролцуулсан байх, энэ талаар нийтэд мэдээлсэн байх | | |

**Эрх зүйн үндэслэл:**

- **Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11**
- **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.5; 4. 1.2.6: 4.1.2.7;**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | 7.1. Өргөдөл, гомдол, хүсэлтийг утсаар, цахимаар, бичгээр гэх мэт хэлбэрээр хүлээн авч, бүртгэлийг цахимжуулах, шийдвэрлэсэн талаар цахим сайтаар мэдээллэх | Жилдээ | Ирүүлсэн гомдол, санал хүсэлтийг бүртгэсэн байх. Шийдвэрлэлтийн мэдээ судалгааг нэгтгэгдсэн байх | Цахим хэлбэрээр хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна. | ТЗУГ, ТҮТ, /Татварын албад/ |
| | 7.2.Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаарх судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах | Жилдээ | Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. | | ТТХГ /Татварын албад/ |

**Эрх зүйн үндэслэл:**

- **Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8**
- **Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2;**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | 8.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтанг томилж, ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг албан тушаалын тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах | Жилдээ | Авлигатай тэмцэх хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө оруулгын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэж хянах, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа хэвшсэн байх | Авлигын эсрэг хууль тогтоомж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийн дагуу зохион байгуулсан байна. | ТЗУГ ЭБАТ /Татварын албад/ |
| **Эрх зүйн үндэслэл:**<br>• **Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9 6.1.12,6.8;**<br>• **Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1;7.1.2.7.2.4,7.2.5,7.2.6, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл;** | | | | | |
| 9 | 9.1. Татварын ажилтны зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг, хүлээн авч, зохих журмын дагуу шийдвэрлэж, мэдээллийг цахим хуудсанд ил тод байршуулах | Жилдээ | Ирсэн мэдээллийг бүрэн шийдвэрлэсэн байх ,<br>Ил тод байршуулсан байх | Авлигын эсрэг хууль тогтоомж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх талаар Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэл хэрэгжсэн байна. | ТЗУГ /Татварын албад/ |
| | 9.2. Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулан, давхар ажил эрхлэлтийн талаарх судалгааг хийж, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгох | Тухай бүр | Давхар ажил эрхлэлтийн судалгааг хийсэн байх<br>Давхар ажил эрхлэсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байна. | | ТЗУГ ЭБАТ /Татварын албад/ |
| | 9.3. Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал үйлчилгээний жагсаалтыг гаргах, ашиг сонирхлын зөрчлийг хянуулах | Тухай бүр | Ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянасан байна. | | |
| **Эрх зүйн үндэслэл:**<br>• **Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10;**<br>• **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.7.3;** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | **10.1. Удирдлагаас өгсөн төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр/ тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах** | **Тухай бүр** | **Цахим хуудсанд байршуулсан байх** | **Төрийн байгуллага , түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, хяналт тавих тогтолцоог бүрдүүлнэ** | **ХХХГ /Татварын албад/** |
| | **10.2. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж/ хуульчилсан акт/, дүрэм журам зааврыг цахим хуудсандаа байршуулах** | **Тухай бүр** | | | |
| 11 | **11.1. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан зөвлөмж, шийдвэрийг биелүүлэх** | **Тухай бүр** | **Зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулж ажилласан байх Шийдвэрийн биелэлтийг хангасан байх** | **Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, шийдвэр хэрэгжсэн байна.** | **ТЗУГ /Татварын албад/** |
| | **Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулах, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг цаг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллах** | Жилдээ | **Төлөвлөгөө боловсруулж, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.** | **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, батлуулах, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж хэвшсэн байна.** | **ТЗУГ ЭБАТ /Татварын албад/** |

**Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж болон харьяа нэгж, Татварын албад 2019 оны 12 дугаар сарын 05-ны дотор Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.**

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА **Л.НЭРГҮЙ**

БОЛОВСРУУЛСАН:
ТАТВАРЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ **П.УНДАРМАА**

УХА0590
6097898
1113127478